АШУҮИС МОНГОЛ УЛСЫН СОЁЛ УРЛАГИЙН ИХ СУРГУУЛЬ

## ТӨРИЙН ӨМЧИЙН 6 ИХ СУРГУУЛИЙН ЗАХИРЛУУДЫН ХАМТАРСАН ТУШААЛ

2022 оны 03 дугаар сарын 16-ны өдөр Дугаар А/61, А/56, А/56, А/191, А/178, А/80 Улаанбаатар хот

Оюутны үйлчилгээ, хөгжлийн чиглэлээр 2022 онд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө батлах тухай

Монгол Улсын Дээд боловсролын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1, 3.2, 11 дүгээр зүйлийн 11.3 дахь хэсэг, 2021 оны 02 дугаар сарын 26-ны өдөр байгуулсан “Төрийн өмчийн их сургуулиудын хамтын ажиллагааны санамж бичиг”-ийн 2 дугаар зүйлийн 2.4.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Төрийн өмчийн 6 их сургуулийн оюутан, суралцагчдын нийгмийн идэвх, оролцоог дээшлүүлэх, оюутны үйлчилгээ, хөгжил хариуцсан нэгж, оюутны холбоо, зөвлөл, клубийн үйл ажиллагааг уялдуулах чиглэлээр 2022 онд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг хавсралт ёсоор батлалсугай.

2. Төрийн өмчийн 6 их сургуулийн оюутан, суралцагчдыг оюутны үйлчилгээ, хөгжлийн чиглэлээр хамтран хэрэгжүүлэх ажлуудад жигд оролцуулах, шаардлагатай санхүүжилтийг их сургуулиуд хуваан гаргахыг тухайн асуудал хариуцсан дэд захирал, газар, албадын дарга нарт тус тус үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын их сургуулийн Сургалт, оюутан хариуцсан дэд захирал (Д.Бадмаанямбуу), Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн Сургалт, оюутны асуудал эрхэлсэн дэд захирал (Н.Ганзориг), Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн Боловсрол хариуцсан дэд захирал (Г.Батбаатар), Соёл, урлагийн их сургуулийн Сургалт эрхэлсэн дэд захирал (Д.Одсүрэн), Хөдөө аж ахуйн их сургуулийн Сургалт эрхэлсэн

дэд захирал (Р.Чанцалдулам), Монгол Улсын Боловсролын их сургуулийн Сургалт эрхэлсэн дэд захирал (Н.Мягмарцоож) нарт тус тус үүрэг болгосугай.

АНАГААХЫН ШИНЖЛЭХ УХААНЫ
ҮНДЭСНИЙ ИХ СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ
ПРОФЕССОР Н.ХҮРЭЛБААТАР

............................................

МОНГОЛ УЛСЫН БОЛОВСРОЛЫН
ИХ СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ
ДЭД ПРОФЕССОР О.АЛТАНГОО

............................................

МОНГОЛ УЛСЫН ИХ
СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ
ПРОФЕССОР Б.ОЧИРХУЯГ

............................................

ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИЙН
ИХ СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ
ПРОФЕССОР Т.НАМНАН

............................................

ХӨДӨӨ АЖ АХУЙН
ИХ СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ
ПРОФЕССОР Т.ХЭРҮҮГА

............................................

СОЁЛ, УРЛАГИЙН ИХ
СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ
ПРОФЕССОР Э.СОНИНТОГОС

............................................

Төрийн өмчийн их сургуулийн захирлуудын
2022 оны 03 дугаар сарын 16-ны өдрийн
А/69, А/80, А/56, А/91, А/118 дугаар
хамтарсан тушаалын хавсралт

**Төрийн өмчийн 6 их сургуулийн хамтын ажиллагааны санамж бичгийн хүрээнд оюутны хөгжлийн чиглэлээр хамтран зохион байгуулах ажлын төлөвлөгөө**

| № | Ажлын нэр | Хэзээ | Хаана | Хариуцах сургууль | Тайлбар |
|---|---|---|---|---|---|
| 1 | Оюутны үнэт зүйлийн судалгаа | 3, 4-р сар | Сургууль бүр дээр | СУИС, МУИС | Нийт оюутнууд |
| 2 | Хотын соёл аян | 3 болон 10-р сар | Сургууль тус бүрийн сургалтын анги, танхим | ШУТИС | Нэгдүгээр курсийн оюутнууд |
| 3 | Оюутны спорт наадам | 4 сар | Сургуулиудын спорт заал | МУБИС | Нийт оюутнууд |
| 4 | "Шилдэг инноватор" оюутны инновацын бүтээл шалгаруулах | 5 сар | ХААИС | ХААИС | Нийт оюутнууд |
| 5 | Эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг | 9 сар | Сургууль тус бүр дээр | АШУҮИС | Нэгдүгээр курсийн оюутнууд |
| 6 | Зөвлөх багш нарын нэгдсэн сургалт, семинар | 9 сар | Сургууль тус бүр дээр | ШУТИС | Нэгдүгээр курсийн зөвлөх багш нар |
| 7 | Эх байгальдаа ээлтэй аялцгаая явган аяллын тэмцээн | 9 сар | ХААИС | ХААИС | Нийт оюутнууд |
| 8 | Оюутны байгууллагуудын солилцоо, туршлага судлах | 10, 11 сар | Сургууль бүр дээр | МУИС | Оюутны холбоо, оюутны зөвлөл, клубүүд |
| 9 | Оюутны эрдэм шинжилгээний хурал | 11 сар | МУИС-ийн дугуй заал | МУИС | Нийт оюутнууд |
| 10 | Урлагийн наадам | 11 сар | СУИС болон сургуулиудын урлагийн заал | СУИС | Нийт оюутнууд |
| 11 | Эрүүл мэндийн боловсрол олгох сургалт | Жилийн турш | Сургууль бүр дээр | АШУҮИС | Нийт оюутнууд |

* Шаардлагатай санхүүжилтийг их сургуулиуд хуваан гаргах үүрэг хүлээнэ.